



БҮРТГЭСЭН ХАНДАЛТ 524↑ (сүвгаар)

УТСААР
385↑



Суваг	2024	2025
	09.12	
☎	589	337
👤	13	11
🌐	19	27
💬	1	61
✉	24	20
💬	11	13
#	657	469


Нийт дуудлага
1118↓

Хүлээн авсан дуудлага
385↑

Дуудлага авсан
37.5%↑

eMongolia-д шилжүүлсэн – 90↓
Алдсан дуудлага – 643↓

ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН БАЙГУУЛЛАГА



ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ



ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

ЧД-5, 6 хороолол 18-р байрны урдуур /зүүн талд/ явсан авто машины замыг хааж хаалт хийсэн болон авто зам дээр дур мэдэн төмөр хаалт зоосныг авч уг замыг чөлөөлж өгнө үү. Гэрлүүгээ болон байрлуугаа орох боломжгүй болоод байна. Мөн уг 18 дугаар байрны урд байрлах нийтийн эзэмшлийн авто зогсоолыг дур мэдэн төмөр хаалт зоосныг авч уг замыг чөлөөлж өгөх талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

ХУД-23, Нүхт палас 1101-р байрны оршин суугч байна. Оч гялс орон сууцны контороос манай байрны хэрэглээний усыг таслаад байна. Сүүлийн 14 хоног тасарч байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

БЗД-3, 60-р байрны оршин суугч байна. Манай байрны урд талд "Номлолт" ХХК нь орон сууцны хотхон барьж байгаа юм. Барилга хоорондын стандарт хангаагүй манай байрны үзэгдэх орчин хааж барилга барьж байгаад гомдолт гаргаж байгаа юм. Оршин суугчдад хэлэхдээ 2 давхар сургууль барьж байгаа гэсэн. Гэтэл 4 давхар худалдаа үйлчилгээний газар барьж байгаа юм байна. Ямар ч зураг төсөлгүй барилгын чанар шаардлага хангаагүй зөвшөөрөлгүй баригдаж байгаа талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:

346↓

ХАРИЛЦАХ ТӨВ
11:11

ХАРИЛЦАХ ТӨВ
11:11

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

✓ Багахангай дүүргийн Улсын бүртгэлийн ахлах бүртгэгч н.Батдэлгэр, бүртгэгч н.Пүрэвдорж архив бичиг хэргийн эрхлэгч н.Сансармаа нарт үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг минь түргэн шуурхай шийдвэрлэж өгсөн баярлаж талархаж байна. Танд болон танай хамт олонд цаашдын ажилд нь өндөр амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

- Миний бие 8 сарын 26 нд Монополийн эсрэг газарт гомдол гаргасан. Гэтэл тус газрын мэргэжилтэн миний гаргасан гомдлын дагуу хариу арга хэмжээ авахгүйгээр зогсохгүй 94030800 дугаарын хэрэглэгчтэй 7 хоногийн турш холбогдох гээд чадахгүй байна гэсэн хариу тайлбар өгсөн. Энэ газрын тус мэргэжилтэн миний гомдол гаргасан хүнтэй ямар нэгэн хамааралтай болоод хамгаалаад байна уу эсвэл огт холбогдоогүй байж надад худал хэлсэн үү? Миний бие иймд Монополийн газарт гомдолтой 115 дугаарын утас нь дуудаж, дуудаж таны өмнөх хэрэглэгчтэй холбогдож байна гээд утас тасардаг. Миний гомдлыг заавал ажлын 30 хоногт багтааж шийднэ гээд хуулийн хугацааг хүлээж цаг алдаад байгаа юм уу эсвэл үнэхээр их гомдол өргөдөлд дарагдаад миний хүсэлт хариу өгөхгүй байгаа юм уу. Миний бие мөнгөө төлж бараа авах захиалга өгөөд хүссэн бараагаа авч чадаагүйн төлөө бараагаа авсан даруйдаа буцаахыг хүссэн боловч тус газар надад татгалзсан хариу өгсөн. Тиймээс Монополийн газар нь арга хэмжээ авч намайг хохиролгүй болгож өгнө үү гэсэн хүсэлтийг тавьсан. Гэвч тус байгууллагын миний гомдлыг хариуцаж буй мэргэжилтэн ажлаа хийхгүй байгаад гомдолтой байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ

- Баянхонгор аймгийн нийгмийн даатгалд ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ 4 дүгээр сарын 4-нд өгсөн. Одоог хүртэл хуваарийн дагуу нэг ч удаа олгогдоогүй байна. Үлдэгдэл тэтгэмжээ авахыг хүсэж байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.
- Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт 2025.07.31-ний өдөр СХД-ийн Нийгмийн даатгал руу илгээсэн. Баталгаажсан байгаа боловч бичиг баримт хэвийн гэж байсан. 2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр очоод уулзтал таны хүсэлтийг цуцалсан байна гэсэн мэдээлэл өгөөд байх юм. Би өөрийн биеэр материалаа бүрдүүлээд СХД-ийн нийгмийн даатгалын байцаагчид хүлээлгэн өгсөн. Энэ асуудлыг шалган шийдвэрлэж хариу өгнө үү.

ЦЭЦЭРЛЭГ

- Манай хороонд улсын цэцэрлэг байдаггүй. Хүсэлт өгөхөөр дандаа хувийн цэцэрлэгт хуваарилагддаг. Тус хувийн цэцэрлэгүүд нь төлбөр өндөр, орчин муутай, тоглоомын талбай байдаггүй, улсын цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулж, манай хүүхдийг улсын цэцэрлэгт хуваарилж өгнө үү. Цааш нь холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.
- ХУД-23, 12-р цэцэрлэгийн салбар нь ангид нь хүүхэд тоглох тоглоом шүүгээ сав огт байхгүй. Хоосон ангид хүүхдүүддээ хүлээн авч байна. Санхүүжилт байхгүй гэсэн мэдээлэл өглөө. Улс үүнийг тохижуулах ёстой. Иймд үүнийг яаралтай шийдвэрлэж өгнө үү.

АВТО ЗАМ

- ЧД-ийн Хайлаастын уулзвараас 7 буудал явах замыг шинэчлэн засварлахдаа Хайлаастын уулзвар нэвтрээд зүүн эргэх буюу Далайхүү төв, МТ колонк, Хайлаастын 1-5 дугаар гудамжны айл өрхүүд эргэж ордог орцны тасархай зураасыг үргэлж зураас болгож алдаатай хийсэн байна. Үүний улмаас оршин суугчид орж байсан хэсгээрээ нэвтрэх чадахгүй байгаа тул замын тэмдэглэлгээг буруу хийсэн байгааг засаж орцыг нээж өгнө үү, замын тэмдэглэгээ хийсэн компани тасархай зураасыг буруу хийсэн байна
- ❖ БГД-20 хорооны иргэн би 5 шарын хуучин прьезер хаагдсанаас үүдэлтэй босоо тэнхлэгт нэвтрэх эрхийг хязгаарласан үйлдэлд маш их гомдолтой байна. Хорооны хэсгийн ахлагчид мэдэгдсэн ч хүлээж авсангүй. 1111-т удаа дараа мэдэгддэг. Сайн ч дамжуулж уламжилж өгдөг олон мэргэжилтэнд дамжиж шийдвэр гаргахгүй байна. Иймд 1.ЗТЯ Үндсэн хуулийн 16 зүйлийн 18-д улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхэд нөлөөлсөн шийдвэр гаргасан. 2.Замын хөдөлгөөний үндэсний зөвлөлд энэ гарц, гарамтай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхийг хүсэж байна. Энэ нь үндэсний зөвлөлийн даргад хүргүүлэх хүсэлтэй. 3.Төмөр замын удирдах газар маш олон иргэдийн эрх ашгийг харгалзан үзэлгүйгээр нэг талыг барьж босоо тэнхлэгт иргэдийн зорчих эрхийг хязгаарладаг. Манай гэр бүл 5 гишүүнтэй. Тус бүрийн зорчих эрх хөндөгдөнө. 4.Төмөр замын галт тэрэг нь дуут дохиог хотын төвд хэрэглэдэг нь зам тээврийн хууль, дүрэм журмыг шууд зөрчдөгт арга хэмжээ авах. 5.Энхжин төвийн нүхэн гарцруу нэвтрэхэд ойр орчимд тээврийн хэрэгсэл маш их байдаг. Нүхэн гарц руу очих чиглэлд саад их. Иймд энэ асуудлыг зөвхөн Нийслэлийн засаг даргад, Нийслэлийн засаг дарга шийдвэрлэсэн гэж үзвэл замын хөдөлгөөний үндэсний зөвлөлд хүргүүлэх хүсэлтэй байна.

ТӨВ ЭМНЭЛЭГ

- ✓ Өргөө амаржих газрын мэс заслын эмч Д.Өнөржаргал, Ю.Болор, Б.Мөнх-Оргил, сувилагч Г. Энхчимэг, н.Содончимэг, н. Төгс, н.Лхамжав, мэдээгүйжүүлэгч эмч н.Баасансүрэн нарын хамт олонд талархал илэрхийлмээр байна. Та бүхнийхээ эелдэг найрсаг харилцаа, мэргэжлийн ур чадвар, сайхан сэтгэлийн ачаар өвчин зовлонгоосоо салж чадлаа. Та бүгдийн цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье. Уламжилж өгнө үү.
- Би 2025.09.09-нд ЭХЭМҮТ-д хүүхдээ үзүүлэхээр хандсан. Хүүхдийг маань чихний буглаа үүссэн тул хагалгаанд оруулах шаардлагатай гэсэн. Хэвтүүлж хагалгаа хийнэ гээд 2 хоног явуулсанд гомдолтой байна. Өнөөдөр хэвтүүлэхгүйгээр өдрөөр хагалгаа хийнэ гэсэн боловч, яах нь тодорхойгүй одоог хүртэл хүлээлгэж байгаад гомдолтой байна. Холбогдох газарт нь уламжилж, шийдвэрлэж өгнө үү.

ХАМГИЙН ИХ ХАНДАЛТ
АВСАН АСУУДАЛ

ХАМГИЙН ИХ ХАНДАЛТ
АВСАН АСУУДАЛ